

“БАЯНТЭЭГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2016 оны 03 сарын 23 өдөр

Арвайхээр сум

“Баянтээг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал 2016 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 10:00 цагт Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, “Нутгийн удирдлагын ордон”-ны 3 давхарт 303А танхимд эхлэв.

Хуралд оролцогчид 100% санал нэгтгэйгээр хурлын даргаар О.Батжаргал сонголоо.

Хурлын дарга: “Баянтээг” Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа, Та бүхэнд хурлын ирцийг танилцуулъя, “Баянтээг” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд **2** хувьцаа эзэмшигч, нийт хувьцааны **93.53%** буюу **236,277** ширхэг хувьцааны ирцтэй байгаа тул хурлын ирц хүрсэнд тооцож, хурлыг нээлээ.

Хурлаар хэлэлцсэн асуудлуудын жагсаалт:

- a. Компанийн 2015 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайлан,
- b. Аудитын хорооны тайлан дүгнэлт,
- c. Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх удирдлагын 2016 оны цалин урамшуулал болон зардлын төсөв,
- d. Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд заасны дагуу хөндлөнгийн байгууллагаар аудит хийлгэх,
- e. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох,
- f. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэх.

Саналын хуудсаар дараах шийдвэр гарав:

Тооллогод нийт хувьцаа эзэмшигчдийн **93.53 %** буюу **236,277** ширхэг хувьцаа эзэмшиж буй **2** хувьцаа эзэмшигчдийн саналыг саналын хуудсаар авсан ба **2** буюу **100%** хүчинтэй байлаа.

Кумулятив аргаар өгөх саналын эрх 2,599,047 /нийт хувьцааг х 11/.

1. Компанийн 2015 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайланг хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0 % нь түтгэлзсэн, 0 % нь татгалзсан байна.
2. Аудитын хорооны тайлан дүгнэлтийг хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь түтгэлзсэн, 0 % нь татгалзсан байна.
3. Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх удирдлагын 2016 оны цалин урамшуулал болон зардлын төсвийг хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0 % нь түтгэлзсэн, 0 % нь татгалзсан байна.
4. Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд заасны дагуу хөндлөнгийн байгууллагаар аудит хийлгэх тухай дүрэмд нэмэлт оруулахыг хувьцаа эзэмшигчид 100 % зөвшөөрсөн, 0 % нь түтгэлзсэн, 0 % нь татгалзсан байна.
5. Компанийн шинэ Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдэд кумулятив аргаар өгсөн санал:

Ердийн гишүүдэд:

	Нэр	Саналын хувь
1	Д.Энхбат	9.09%
2	М.Нинжбадгар	9.09%
3	Ж.Самданжинмэд	9.09%
4	О.Батжаргал	9.09%
5	Д.Нэмэхбаяр	9.09%
6	Ю.Батсайхан	9.09%
7	Б.Баясгалан	9.09%

Хараат бус гишүүдэд:

	Нэр	Саналын хувь
1	Т.Бадрах	9.09%
2	З.Дашзэвгэ	9.09%
3	Г.Батсүх	9.09%
4	Л.Пүрэв	9.09%

тус тус санал авч, шинэ ТУЗ-ийн гишүүд сонгогдов.

6. ТУЗ-өөс гаргасан Компанийн ногдол ашгийн талаарх шийдвэрийг хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0 % нь түтгэлзсэн, 0 % нь татгалзсан байна.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ц.Цог

/ Ц.Цог/